



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Криптовалютын хэтэвчинд хууль бусаар нэвтэрч өөрт шилжүүлэн авч арилжсан)¹

САНАМЖ: Энэхүү хураангуй нь гагцхүү олон нийтэд мэдээлэл болгох зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хуулийн хүчин төгөлдөр анхан шатны шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2022/ШЦТ/645

Шүүхийн шийдвэрийн огноо: 2022 оны 05 дугаар сарын 03

Шүүгдэгч: О.Б

Хохирогч: Т.Т

Шүүхийн шийдвэр: Криптовалютын хэтэвчинд нэвтэрч цахим мэдээлэлд хууль бусаар халдаж, улмаар бусдын эзэмшлийн криптовалютыг өөрт шилжүүлэн авч цааш арилжин мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн.

Шийдвэрийн төлөв: Хүчин төгөлдөр анхан шатны шүүхийн шийдвэр.

Маргааны төрөл: “Цахим мэдээлэлд хууль бусаар халдах”, “мөнгө угаах” гэмт хэрэг.

Шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:
https://shuukh.mn/single_case/66652?daterange=2022/01/01%20-%202022/08/05%20&id=1&court_cat=2&bb=1

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

1. Шүүгдэгч О.Б нь хохирогч Т.Т-н DAX нэртэй криптовалютын биржид бүртгэлтэй хэтэвчинд байсан 2.383.710 ширхэг ИНС койныг авах зорилгоор 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс 30-ны өдрийн хооронд хохирогчийн и-мэйл хаягаар дамжин нэвтрэх оролдлого хийж, DAX нэртэй криптовалютын биржид бүртгэлтэй хэтэвчинд нэвтрэх буюу цахим мэдээллийн сүлжээнд тусгай программ ашиглан хууль бусаар халдаж нэвтрэн, улмаар тус бирж дээр гүйлгээ хийхэд шаардагдах нэг удаагийн нэвтрэх нэр, нууц үгийг хохирогч Т.Т-н гар утсанд суулгасан Ard аппликейшнд ирсэнийг мөн хууль бусаар олж авч, мэдээллийг өөрчилсөн, мэдээлэл нэмж оруулсны улмаас хохирогчид 2.383.710 ширхэг ИНС койн буюу 10.478.147 төгрөгийн хохирол учруулсан;
2. Улмаар 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 00 цаг 29 минутын үед хохирогч Т.Т-г DAX нэртэй криптовалютын биржид бүртгэлтэй хэтэвчинд байсан 2.383.710 ширхэг ИНС койныг цахим мэдээлэлд хууль

¹ Эрүүгийн эрх зүйн маргааны шүүхийн шийдвэрийн хураангуйг боловсруулахдаа Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 2022/ШЦТ/645 дугаартай шийтгэх тогтоолыг ашигласан болно.



бусаар халдах замаар, өөрийн Binance нэртэй криптовалютын бирж дэх хэтэвчиндээ шилжүүлэн авч USDT койн болгон хувиргаж эзэмшжээ.

ХУУЛИЙН ХЭМ ХЭМЖЭЭ

3. Шүүх О.Б-н дээрх үйлдлүүдийг “Цахим мэдээлэлд хууль бусаар халдах” гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдэх буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан *“Цахим төхөөрөмж, мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдаж мэдээллийг устгасан, гэмтээсэн өөрчилсөн, засварласан, хуулбарлаж авсан, мэдээлэл нэмж оруулсан, программ хангамж, сүлжээг ашиглах боломжгүй болгосон, хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан; компьютерийн системд санаатайгаар хууль бусаар мэдээлэл дамжуулсан, үйл ажиллагаа хязгаарласан; мэдээлэл хадгалагдаж байгаа төхөөрөмжийг устгасан, гэмтээсний улмаас бусдын хууль ёсны ашиг сонирхолд хохирол учирсан”* гэмт хэрэг;
4. Мөн Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан *“Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдлах”* буюу “Мөнгө угаах” гэмт хэргийг тус тус үйлдсэн гэм буруутайд тооцжээ.

ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

5. Анхан шатны шүүхээс шүүгдэгч О.Б-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн “Цахим мэдээлэлд хууль бусаар халдах” гэмт хэргийг 26.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн, мөн 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Мөнгө угаах” гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож нийт 1 жил 6 сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэжээ.